

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГЫН НУУЦ  
ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах, ашиглахад энэхүү журамыг мөрдөнө.
- 1.2. Байгууллагын нууц хамгаалах ажлыг Засаг даргын Тамгын газрын даргын шууд удирдлагын дор нийт ажилтан албан хаагчид хариуцаж, нууц хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.
- 1.3. Засаг даргын Тамгын газрын дарга нууцын ажилтны үүргийг байгууллагынхаа аль нэг ажилтанд хавсруулан гүйцэтгүүлж болох бөгөөд уг ажилтан нь төрийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, тагнуулын байгууллагаас шалгаж зөвшөөрсөн Монгол улсын иргэн байна.
- 1.4. Засаг даргын Тамгын газрын дарга нь байгууллагын нийт ажилтан, албан хаагчдаас байгууллагын нууц задруулахгүй байх баталгааг гаргуулан авна.
- 1.5. Байгууллагын нууцыг хариуцаж байгаа, эсхүл түүнтэй албан үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны дагуу танилцсан, олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй бөгөөд аливаа зорилгоор задруулахыг хориглоно.

Хоёр. Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хадгалах, хамгаалах

- 2.1. Засаг даргын Тамгын газрын ажилтнууд байгууллагын нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хадгалах шаардлага хангасан өрөө эсвэл тусгайлсан сейфтэй байна.
- 2.2. Байгууллагын нууцад хамаарах баримт бичиг хадгалагдаж буй байр өрөөгөө цоожлохгүй орхих, сейфээ бусдын дэргэд онгорхой үлдээх, ил задгай орхин түр хугацаагаар холдохыг хориглоно.
- 2.3. Засаг даргын Тамгын газрын харуулын ажилтнууд байгууллагын нууцад хамаарах баримт бичиг хадгалагдаж буй байр өрөөг ажил дууссаны дараа цоожилж лацдан харуулд бүртгэлээр хүлээлгэн өгөх бөгөөд ажил эхлэхийн өмнө өрөө, сейфнийхээ лацыг шалган сэжигтэй шинж тэмдэг илэрвэл Засаг даргын Тамгын газрын даргад мэдэгдэж, харуулыг байлцуулан өрөөнд нэвтрэх буюу цоожийг онгойлгож, 2-оос цөөнгүй албан тушаалтныг байлцуулан байгууллагын нууцад хамаарах баримт бичиг, биет зүйл бүрэн эсэхийг шалгана.

Гурав. Байгууллагын нууцтай танилцах

- 3.1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, тэдгээрийн ажилтан нь хянан шалгах бүрэн эрх, чиг үүргийнхээ дагуу байгууллагын нууцтай танилцана.
- 3.2. Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.

3.3 Эрх бүхий байгууллага, албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж нууцалсан байгууллагын нууцыг ил болгох эрхтэй бөгөөд тухайн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдолтой байгууллагын нууцад хамаарах зарим тодорхой мэдээллийг бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй тохиолдолд нийтэд мэдээлж болно.

Дөрөв. Байгууллагын нууц задарсан, байгууллагын нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, баримт бичиг, эд зүйл үрэгдсэн тохиолдолд авах арга хэмжээ

4.2. Байгууллагын нууц задарсан, нууцалсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, эд зүйл үрэгдсэн тохиолдолд түүний шалтгааныг тогтоох арга хэмжээг Засаг даргын Тамгын газрын дарга шуурхай авч хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

4.3. Энэхүү журмыг зөрчсөн, байгууллагын нууцыг хариуцдаг, эсхүл түүнтэй танилцсан этгээд уул нууцыг задруулсан бол Засаг даргын Тамгын газрын дарга сахилгын шийтгэл ногдуулах буюу захиргааны шийтгэл ногдуулахаар шүүхэд шилжүүлж болно.